

**“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ”
ОНӨААТҮГ**

Өөрийн байр, Морингийн даваа,
10 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17122
Утас: (976) 9900 2974

Цахим шуудан: zorchigchteewer4@gmail.com

2024.08.23 № 1/89
танай _____-ны № _____-т

Тодруулга өгөх тухай

Шатахуун /Дизель түлш/ худалдан авах ЗТДОНӨААТҮГ/20240102001 дугаартай тендер сонгон шалгаруулалтад танай компаниас ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Тус газар нь Авто тээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д нийтийн тээврийн тодорхойлсон бөгөөд дэд бүтцийн суурь нийгмийн захиалгат, иргэд зорчигчдын нийтийн тээврийн хэрэгцээ шаардлагыг ханган нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэдэг орон нутгийн өмчит байгууллага тул нийтийн тээврийг хэвийн тасралтгүй явуулахтай холбогдуулан Тендерийн баримт бичгийн ТШЗ-ийн 21.5-д "Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад **"Тохируулахгүй тогтмол байна"** гэж заасан. Иймд "Гэрээний хэрэгжилтийн явцад гэрээний суурь үнэ +/- 10% өөрчлөгдсөн үед үнийн тохируулга хийж болно" гэсэн заалт оруулах боломжгүйг мэдэгдэж байна.

2. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Автобус парк" төслийн хүрээнд байгуулагдсан автобус баазад тус газрын үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд шатахуун түгээх станцын барилга байгууламж ашиглалтад орохоор төлөвлөгдөж байгаатай холбогдуулан 2024 оны нийлүүлэгдэх түлшний задаргааг сар бүрээр гарган хавсралтаар хүргүүлж байна.


Хавсралт 1 хуудастай.

ЗАХИРАЛ



С.БЯМБАСҮРЭН

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын
2024 оны 8 дугаар сарын сарын 31-ны өдрийн
11.89 дугаар албан бичгийн хавсралт



НИЙЛҮҮЛЭГДЭХ ЕВРО-5 ДИЗЕЛЬ ТҮЛШНИЙ ЗАДАРГАА

д/д	Он, сар	Өдөр	Шаардлагатай түлш /литр/
1	2024-09	30	280,279.9
2	2024-10	31	292,376.7
3	2024-11	30	278,225.8
4	2024-12	31	290,322.6
Нийт			1,141,205

ооо